

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Жамсрангийн Самбуу Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу, одоогийн Төв аймгийн Бүрэн сумын нутагт 1895 оны 6 дугаар сарын 25-нд мэндэлжээ. Тэрээр 1903 онд нутгийн сайн бичээч Дугарсүрэн гэж хүнд шавь орж гэрээр бичиг үсэг сурч хошуу тамгын газар бичээч болж, 1950 онд Намын шинэ хүчний сургуульд суралцаж төгсжээ.

Жамсрангийн Самбуу 1912 оноос Нийслэл хүрээний Түмтийн өртөөнд улаач, 1921 оноос Түшээт вангийн хошууны тамгын газар хавсраа бичээч, 1923 оноос Ардын Засгийн газрын Сангийн яаманд гутгаар зэргийн нягтлан бодогч, 1926 оноос тэргүүн зэргийн нягтлан бодогч түшмэл, 1928 онд эрхэлсэн түшмэл, 1930 оноос Богдхаан уулын (одоогийн Төв аймаг) аймгийн дарга, 1931 оноос Өмнөговь аймгийн дарга, 1932 оноос тус аймгийн шүүхийн даргаар ажиллаж байв. 1934-1937 онд Мал тариалангийн яаманд хэлтсийн дарга, 1937-1941 онд БНМАУ-аас ЗСБНХУ-д (хуучин нэрээр) суух Бүрэн эрхт төлөөлөгч, 1941-1946 онд Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, 1946-1950 онд онд Гадаад явдлын яамны Алс Дорнодын хэлтсийн дарга, 1950-1952 онд БНАСАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 1952-1953 онд Гадаад яамны орлогч сайд, 1953-1954 онд Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн орлогч даргаар ажиллажээ.

Тэрээр 1954-1960 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улсын Их Хурлын дарга, 1960-1972 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар удаа дараа сонгогдон ажиллахдаа түүний санаачилгаар улсын хөгжил дэвшилтэй холбоотой олон чухал шийдвэр гарсан байна. Үүнээс үзэхэд, Жамсрангийн Самбуу нь Монгол Улсын төрийн анхан, дунд, дээд шатны албыг 60 жилийн турш ээлж дараатай хашсан, эх орныхоо хөгжил дэвшил, гадаад харилцаанд бодитой хувь нэмэр оруулсан төрийн зүтгэлтэн, дипломатч хүн юм.

Жамсрангийн Самбуу 1935, 1937, 1943, 1945, 1958, 1961, 1965, 1971 онуудад “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал”, “Малчдад өгөх зөвлөгөө”, “Малчин ардын амьдрал ахуй, хэв заншлаас” зэрэг 12 бүтээл туурвисан нь манай эдийн засгийн уламжлалт салбар мал аж ахуй эрхлэгчдэд өдгөө ч үнэ цэнтэй гарын авлага хэвээр байна.

Монголын Улсын төрийн тэргүүн байсан Жамсрангийн Самбуугийн хөдөлмөр зүтгэлийг үнэлж БНМАУ-ын хөдөлмөрийн баатар (1968) цол хүртээж, Сүхбаатарын одонгоор дөрвөн удаа, мөн зарим гадаад орны төрийн дээд шагналуудаар шагнасан бол түүний мэргэн ухаан, төрийн ажлын арга туршлага, ур чадварыг нь ард түмэн үнэлж “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн хүндэтгэн нэрлэдэг байжээ.

Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан манай орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах зорилгоор “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130

жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тогтоолын төсөлд тусгасан.

Тогтоолын төслийн талаар Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Сангийн яамны саналууд болон Шинжлэх Ухааны Академийн дүгнэлтийг хавсаргав.

ТОГТООЛ САНААЧЛАГЧ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Жамсрангийн Самбуу Монгол Улсын ХХ зууны түүхэнд чухал байр суурь эзэлсэн, улс орныхоо хөгжил дэвшил, олон улсын харилцаанд үнэтэй хувь нэмэр оруулсан, төрийн ажил үйлсэд чухал үүрэг гүйцэтгэсэн төрийн нэрт зүтгэлтэн юм.

Тэрээр БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар 18 жил ажиллахдаа олон чухал шийдвэр гаргаж, улс орны хөгжлийг ахиулахад бодитой хувь нэмрээ оруулжээ. Түүнчлэн элчин сайдаар ажиллаж, олон улсын харилцааг бэхжүүлэхийн төлөө идэвх зүтгэлтэй ажилласан нь Монголын дипломат албаны түүхэнд чухал байр суурь эзэлдэг.

Жамсрангийн Самбуу нь төрийн болон дипломат албаны зэрэгцээ олон нийтэд зориулсан үнэ цэнтэй ном, судалгааны бүтээл туурвиж, ард түмэндээ мэдлэг, мэдээлэл түгээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад сануулга сургаал” зэрэг бүтээл нь малчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийг агуулсан чухал гарын авлага юм.

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан улс орны хөгжил дэвшил болон олон улсын харилцааг бэхжүүлэхэд түүний оруулсан үнэтэй хувь нэмрийг үнэлж, амьдрал, үйл ажиллагааг судлан таниулах, залуу үед сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах нь чухал ач холбогдолтой байна.

Иймд Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тогтоолын төсөлд тусгасан.

ТОГТООЛ САНААЧЛАГЧ